

2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хонины ноосоор барилгын дулаан тусгаарлах материал үйлдвэрлэх  
үйлдвэрлэл

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

/П.Шинэцэцэг/

Дархан- Уул аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн

/Д.Баянмөнх/

Хэрэгжилтийг хангасан:

“Эко ноос” ХХК-ийн

Байгаль орчны чанарын ажилтан



/Ш.Ганбаатар/

Дархан-Уул аймаг

2022 он

**Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийн  
тайлангийн агуулга**

Төслийн товч танилцуулга

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
3. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
4. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
6. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт
7. Дүгнэлт

## **“ХОНИНЫ НООСООР БАРИЛГЫН ДУЛААН ТУСГААРЛАХ МАТЕРИАЛ ҮЙЛДВЭРЛЭХ” ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2008 оноос төслийн баг монгол хонины ноосоор барилгын дулаан тусгаарлах материал үйлдвэрлэх чиглэлээр судалгаа хийн “Хонины ноосон барилгын материал үйлдвэрлэх үйлдвэр байгуулах” төсөл боловсруулсан. энэхүү төслийг хэрэгжүүлэх зорилгоор 2011 онд “Эко ноос” ХХК байгуулсан.

Манай компани 2013 оны 9 сард “Чингис бонд”-ын санхүүжилтээс 6,4 тэрбум төгрөгийн зээлийг авч үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж худалдан авсан. 2015 оны 6-8 саруудад үйлдвэрлэлийн угаах болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх иж бүрэн тоног төхөөрөмжийн угсралтын ажлыг дуусгаж 9 дүгээр сард туршилтаар ХААН НООС-ДУЛААН ТУСГААРЛАГЧ бүтээгдэхүүнээ үйлдвэрлэн Япон улсын зах зээл рүү сурталчилан таниулах ажлыг шат дараатай явуулж, шаардлагатай стандарт шалгууруудыг ханган ажиллаж байна.

Бид дэлхийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхаж ноос ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий хонины ноосоор барилгын дулаан тусгаарлах материал үйлдвэрлэх иж бүрэн тоног төхөөрөмжтэй ноос угаах болон боловсруулах үйлдвэрүүдээ ашиглалтанд оруулаад байна. Энэ тоног төхөөрөмжүүд нь бүтээгдэхүүнийг түүхий эдээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн хүртэлх боловсруулалтын бүхий л үе шатыг орчин үеийн техник технологиор цогцоор нь гүйцэтгэнэ.

**Эрхэм зорилго:** Эх орныхоо нөхөн сэргээгдэх, шавхагдашгүй нөөц баялаг болох хонины ноосыг ашиглан хүн, байгаль дэлхийд ээлтэй экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн брэнд болгох

### **Компанийн онцлог:**

Эх орныхоо нөхөн сэргээгдэх, шавхагдашгүй нөөц баялаг болох хонины ноосыг орчин үеийн техник технологиор боловсруулан хүний эрүүл мэнд, байгаль дэлхийд ээлтэй экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлж байгаа нь манай компанийн онцлог юм.

# ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

## 1. Цаг уур, уур амьсгалын нөхцөл байдал үйлдвэрт нөлөөлөх нөлөөлөл

Манай компанийн хонины ноосон барилгын дулаан тусгаарлах материал үйлдвэрлэл нь жилийн 4 улиралд үйл ажиллагаа явуулна.

Уур амьсгалын нөлөөнөөс болж үйлдвэрт учирч болзошгүй нөлөөллүүд,

- ✓ Хадгалах температурын өөрчлөлтөөс шалтгаалан үйлдвэрт ашиглах химийн бодис, угаагч шингэн савангийн найрлага шинж чанарт өөрчлөлт орох
- ✓ Аянга цахилгаан, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр үйлдвэрийн байр, агуулах, хогийн цэг зэрэгт гал гарах
- ✓ Их хэмжээний аадар бороо орсноос үйлдвэрийн байр, агуулах, хогийн цэг болон бусад талбай үерт автах
- ✓ Хүчтэй шуурга салхины нөлөөгөөр үйлдвэр орчмын мод хугарч үйлдвэрийн барилга байгууламж зэрэгт гэмтэл хохирол учруулах

## 2. Үйлдвэрийн үйл ажиллагаа агаарын чанарт нөлөөлөх

Доорх хүснэгтэд үйлдвэр жигд ажиллах үед агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг нөлөөллийн үр дагаварын үнэлгээгээр үнэлэн үзүүлэв.

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
		Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц аюултай
1	Бүтээгдэхүүн тээвэрлэх үед, үйлдвэрийн талбай дахь ургамлан бүрхэвч талхлагдаж салхитай үед тоосонцор агаарт дэгдэх	+				
2	Үйлдвэр дотор ажлын байранд тоос үүсч агаарт дэгдэн орчны агаарыг бохирдуулах, ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөг үзүүлэх		+			
3	Үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, ялангуяа дизель түлшээр ажилладаг хүнд даацын машин, техникийн утаа агаар хаягдах	+				
4	Үйлдвэрт ашиглах түүхий эд болон бодис хадгалах талбай, агуулах зэргээс үүсэх тоосжилт		+			
5	Үйлдвэрийн ажилчдын ахуйн хог хаягдлыг хураах, тогтсон хугацаанд зайлуулаагүйгээс болж ялзрал үүсч орчинд эвгүй үнэр тархах		+			
6	Үйлдвэрлэлийн явцад ашиглагдсан хаягдал ус асгарах, дамжлагын шугам хоолой эвдрэх, бөглөрөх зэргээс орчинд бохир ус алдагдаж уурших		+			

### 3. Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх байдал

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гадаргын болон газрын доорх усны чанарт цөөн хэдэн хүчин зүйлсээр нөлөөлөл үзүүлнэ. Үүнийг доорх хүснэгтээр харуулав.

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
		Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц аюулгүй
1	Ноос угаах үйлдвэр нь голын голдрилын бүтцэд нөлөөлж, байнгын болон түр зуурын урсацыг өөрчилж, голдрилд нөлөөлөх	+				
2	Ашиглалтын явцад бага гүнд орших газар доорх усны түвшин, зарим иргэдийн худаг болон булагуудад нөлөөлөх	+				
3	Голын хөндийн сэвсгэр хурдасны усны нөөцөд нөлөөлөх байдал		+			
4	Бүс нутгийн гадаргын болон газар доорх усны чанарт нөлөөлөх байдал		+			

### 4. Хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдал

Манай үйлдвэрийн үндсэн түүхий эд нь Монгол хонины цэвэр ноос байх тул байгаль орчин, хөрс ургамалд үзүүлэх сөрөг нөлөө бараг байхгүй гэж үзэж байна. Үйлдвэрийн хашаанд байгаа ургамлан нөмрөгийн зонхилох хэсгийг шар царгас бүрдүүлж байгаа нь хөрсний үржил шимийг ихээр нэмэгдүүлдэг тэжээлийн олон наст буурцагт ургамал юм. Аливаа таримал ургамал хөрснөөс шим тэжээлийн бодисыг авч хөрсийг ямагт ядууруулж байдаг бол царгас нь хөрсний үржил шимийг нөхөн сэргээж байдаг.

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
		Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц аюулгүй
1	Шугам хоолойн нүх ухах, салбар төмөр зам засварлах газар шорооны ажлын үед хөрсний элэгдэл үүсэх		+			
2	Үйлдвэрээс гарах хаягдал болон ажилчдын хоол хүнсний хаягдлыг зориулалтын бус газар хадгалах, зайлуулалгүй удсанаас болж хөрсний бохирдол бий болох		+			
3	Үйлдвэрт ашиглах бодис агуулсан хаягдал ус алдагдаж хөрсийг бохирдуулах улмаар хөрсний бага гүний уст үеүдэд шингэх, ургамал, амьтанд сөргөөр нөлөөлөх	+				

## 5. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдал

Үйлдвэрийн талбайд ямар нэгэн нэн ховор, ховор ургамал ургадаггүй тул ховор, ховордож байгаа, устах аюулд орсон унаган ургамалд үйлдвэрийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөлөл байхгүй. Талбайд ургаж байгаа ургамлууд нь элбэг ургадаг ургамлын зүйл учир ургамлын зүйлийн олон янз байдал болон аливаа нэг зүйлийн ургамлыг ховордуулахад нөлөөлөхгүй.

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
		Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц аюулгүй
1	NOx болон SOx тунадастай хамт юм уу хатуу тоос хэлбэрээр ургамлан бүрхэвч дээр бууж цааш хөрсөөр дамжин тархан ургамал, амьтанд сөргөөр нөлөөлөх	+				
2	Осол аварийн үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж, ургамалжилтад сөрөг нөлөөг үзүүлэх, бохирдуулах	+				

## 6. Амьтны аймагт нөлөөлөх байдал

Үйлдвэрийн талбай орчим нь олон төрлийн амьтдын амьдрах орчин болдог тул барилгын ажлын болон ашиглалтын явцад дараах нөлөөлөл үүсэх боломжтой юм.

№	Нөлөөллүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
		Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Онц аюулгүй
1	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас амьтдын амьдрах орчин алдагдах	+				
2	Техноген болон хүний өөрчилсөн орчинтой холбоотойгоор зарим нэг шинэ зүйлийн шавьжуудын тоо толгой өсөх	+				
3	Төслийн нутаг дэвсгэр доторх хөрс хуулалт нь шавьжнуудын амьдрах орчинд нөлөөлөлх	+				

## 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ


Бид бүхэн 5 жил тутамд Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг САТУ ХХК-иар хийлгэдэг бөгөөд 2020 онд нарийвчилсан үнэлгээгээ хийлгэн тухайн оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тодорхойлсон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд үндэслэн боловсруулсан. 2022 онд боловсруулсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь үйлдвэрийн үйл ажиллагааны бүхий л шат дамжлагыг хамран

үйлдвэрлэлийн явцад хүрээлэн буй орчин, байгальд нөлөөлөх сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, уг сөрөг нөлөөллүүдийг бууруулах, үйлдвэр эрхэлж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахад гол зорилго, зорилт чиглэж байсан.

2022 онд Хил гаалийн асуудлаас үүдэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа зогсонги байснаас тухайн онд төлөвлөсөн байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, хор аюулаас урьдчилан сэргийлэх талаарх ажлуудыг бүрэн гүйцэтгээгүй. Гэвч зохих хэмжээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах тал дээр түлхүү ажиллахыг зорин ажиллаа.

### **Дээрх ажлуудын хэрэгжилтийг доор дурдав.**

1. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд ноосноос гарах тоосжилтыг багасган, ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг бууруулах, үйлдвэрлэлийн дамжлагыг боловсронгуй болгож хуучин гар ажиллагаагаар хийдэг байсан дамжлагыг шинэ төхөөрөмжөөр сольсон. Энэ нь агаарт дэгдэх тоосонцорын хэмжээг 87.3% болтол бууруулсан нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхой хувиар бууруулсан, ажлын ачааллыг бас хөнгөвчилсөн болно.



2. Олон улсын стандарт болох Чанарын менежментийн тогтолцоо /ISO9001:2015/; Байгаль орчны менежментийн тогтолцоо /ISO14001:2015/ стандартуудыг байгууллагын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нэвтрүүлж баталгаажуулалт авсан. Үүний хүрээнд оффисын байрыг бүрэн цэцэгжүүлэн үйлдвэрлэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээг авч ажилласан. Мөн нэгдсэн менежментийн тогтолцооны “Магадлан аудит”-аар орж амжилттай хамгаалсан.





3. Ноосны хаягдал, даахь, хөц зэргийг “ Монпеллетс ” ХХК-тай хамтарч ХАА-н бордоо болгон ашиглахаар тохиролцож судалгааны шатанд явж байгаа болно.

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

НЭХЭМЖЛЭХ № . . . .

Нэхэмжлэгч:	Төлөгч:
Байгууллагын нэр: <u>"МОН ПЕЛЛЕТС" ХХК</u>	Байгууллагын нэр: <u>"МОН ПЕЛЛЕТС" ХХК 672444</u>
Хаяг: <u>Увс, Дэлгэр гэгээ</u>	Хаяг: <u>Увс, Далайн тэнгис</u>
Утас: <u>97888774</u>	Утас: <u>97888774</u>
Э-мэйл: <u>monpellets@mel.mn</u>	Гэрээний №:
Банкны нэр: <u>Халх Гага</u>	Нэхэмжлэсэн огноо: <u>2017.09.07</u>
Банкны дансны дугаар: <u>5910 115903</u>	Төлбөр хийх хугацаа: <u>2017.09.07</u>
Регистрацийн №: <u>4259573</u>	

№	Гүйлгээний утга	Төл хэмжээ	Нэгжийн үлд	Нийт үнэ
1	Боломж	100000		2,500,000

Дүн:                   
 НӨАТ:                   
 Нийт дүн: 2,500,000



Мөнгөний дүн: 2017.09.07 болно.

Дарга: М. Бичваларин  
 Хүлээн авсан:                   
 Нийтлэн бодогч:                 



4. Мөн хаягдал өтгө бууцыг бордоо болгон ашиглах боломжтой бөгөөд энэхүү боломжийн талаар холбогдох байгууллагатай хэлцэлийн шатанд явагдаж байна.
5. Ноос угаасан хаягдал усаа саарал ус болгон дахин ашиглахаар БНТУ-ын технологийг, мөн “ЭКОЛОС” ХХК-ны ус цэвэршүүлэх технологийг судалсан, одоо Улаанбаатар хотын “СИТС” ХХК-тай хаягдал ус боловсруулан саарал ус болгон дахин ашиглах талаар судалгааны ажлыг эхлүүлж байна.

You forwarded this message on Thu 2022.09.15 11:56  
 You forwarded this message on Thu 2022.09.15 11:56  
 Galbadakh Lkhagva <setsengineers@gmail.com>

- Сайн байна уу?
- Таныг хоёр удаах үйлдвэрийн хаагдал усыг цэвэршүүлэх технологиийн тооцоо хийхэд дараах мэдээлэл шаардлагатай болно.
1. Үйлдвэрийн хөдөлгөөний хаагдал усны хэмжээ, технологийн
  2. хаагдал усны нийлэгжлэгийн мэдээлэл, Шинэжүүлэх үйлдвэрийн үхчин болов эцсийн гутлагуураас авсан байх.
  3. Үйлдвэр ажлын үе шатгүй эсэх. Эхлэх 8, 12, 24 цагаар ажлааг эсэх
  4. Ажлын үе шатанд хавчлах усны хэмжээ, тонн
  5. Одоо байгаа гутлагуурын тоо, хэмжээ, мэдээлэл
  6. Эсийн гутлагуураас гарч байгаа усны температур
  7. Жилийн 4 улиралд үйлдвэрийн ажиллагаа явц удаа эсэх
  8. Үйлдвэрт ашиглагдаж байна усны эх үүсвэр, (түний эсвэл голын ус)
  9. Хаагдал усыг үйлдвэрийн процессд оруулж ашиглах эсэх.

Технологиийн тооцоо хийсний дараа үүнийг мэдээлэл явуулах болно.

Манай компани нь асууин бохир усыг хүрээлэн буй орнонд шууд нийлүүлэх хэмжээнд хүрээлэн орнуудад байгаа бөгөөд технологийн процессийг утаснаар автоматжуулан системийн туслалцаатай хангаж байна.


Асууин бохир цэвэршүүлэх био станцын жууцны баазуудад сүүлийн 3 жилийн хугацаанд суурилуулсан байна.

Бид асууин болов үйлдвэрийн хаагдал усыг технологийн тооцоо Америкын усны инженеруудтайг тооцоолон аргачлааар хийдэг. Мин энэ тооцоонд мөнхөл орш байгаль цаг үеэрд хүчин үйлдвэрийг байлцуулаж авч үздэг болно. Тухайн газрын далайн түвшин, агаарын даралт, агаарын сийрэгжилт, орнын температур, усны хатуулаг, зайлшгүй авч үзэх ёстой итгэлцүүрүүд зэрэг хүчин зүйлсийг тооцоонд тусгадаг.

Бид үйлдвэрийн хаагдал ус (сөөрөг)энд хиймэл оюун ухаанд суурилсан автоматжуулалтыг үйлдвэрүүдэд сэлэлт болгож байна. Энэ систем нь хаагдал усыг бохирдуулагч үзүүрүүдээр өөртөө элэлт бааз үүсгэн, Энэ дата болон жууцны магнетик агнаар өмнөр хурдтайгаар шинэчилж хийж системийн горимыг удирдана.

Хүндэтгэл  
 Гялбадарх  
 Замбал  
 Мэричигийн инженер  
 СИТС ХХК  
 Утас: 88375566  
 shaluu.ganbaatar  
 Thu 2022.09.15 11:54

Сайн байна уу. Таны мэдээллийн хүлээн авлаа. Уламгүй харуу явуулах болно. Хүндэтгэл  
 ЭКО НООС ХХК-ийн Менежер Ш.Ганбаатар Утас: 9930606 Сайн сайныг хүсье.  
 shaluu.ganbaatar  
 Thu 2022.09.15 11:56



6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний дагуу аянга буух, цахилгаан хэрэгслийн гэмтэл, хэт халалт зэргээс үүдэн гал түймэр гарах болзошгүй аюул, осол сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч тоног төхөөрөмж болон цахилгааны трансформаторын аянга газардуулагчийн бүрэн бүтэн байдлыг шалган, трансформаторт ажиллагааны хяналтыг хийлгэсэн.

**ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭГЧИЙН ТООЛУУР,  
 ГҮЙДЛИЙН ТРАНСФОРМАТОР ШАЛГАСАН ТУХАЙ ПРОТОКОЛ**

2017 оны ... сар ... өдөр № 00000036 аймгаг

1. Хэрэглэгчийн нэр хаяг: .....
2. Ажил гүйцэтгэхэд байлцсан хэрэглэгчийн эрх бүхий ажилтны овог нэр, албан тушаал: .....
3. Ажил гүйцэтгэсэн хангагчийн эрх бүхий ажилтны овог нэр, албан тушаал: .....
4. Гүйцэтгэсэн ажлын утга: .....
5. Тоолуур шалгасан байдал: Тоолуурын марк: ..... № ..... заалт .....  
 Тоолуурын баталгаажилт дуусах огноо: ..... оны ... сарын ... өдөр Лац № ..... лацны өнгө .....  
 Схем холболт Гүйдлийн чиглэл Фазын дараалал
6. Гүйдлийн трансформатор: Марк ..... КТТ .....  
 А фаз: № ..... Лац № ..... өнгө .....  
 В фаз: № ..... Лац № ..... өнгө .....  
 С фаз: № ..... Лац № ..... өнгө .....  
 Гүйдлийн трансформатор баталгаажилт дуусах огноо: ..... оны ... сарын ... өдөр
7. Хэмжилт: Ua - ..... IA - ..... Ia - .....  
 Ub - ..... IB - ..... Ib - .....  
 Uc - ..... IC - ..... Ic - .....
8. Дугналт: .....

Протокол үйлдсэн: .....  
 Протоколыг танилцсан: .....

7. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу барилгын засварын ажлын үед эвдэрсэн газрыг нөхөн сэргээх зүлэгжүүлэх, цэцэрлэгжүүлэх арга хэмжээг жил бүр авч хэрэгжүүлдэг. Манай байгууллагын өмнөх талбайгаар төвийн дулааны шугам дайрдаг бөгөөд дулааны улирлын үеэр урсгал засвар хийгддэг үүний дараагаар бид бүхэн нөхөн сэргээлт хийн зүлэгжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулдаг. Мөн хавар, намрын улиралд борооны ус, цасны хайлсан ус мод, бутны үндсээр дамжин барилгын суурийн чанарыг алдагдуулдаг учир үүнээс хамгаалж ургамал, хог, бутыг цэвэрлэсэн



8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулахад өмнөх жилүүдэд орон нутагт устгалын цэг байдаггүйгээс үүдэн агуулахад хадгалдаг байсан бол энэ оноос Химийн бодисын сав баглаа, боодлыг устгах, дахин боловсруулах үйлдвэрүүд байгуулагдсанаар энэхүү нөлөөлийг 100% бууруулах бүрэн боломж бий болсон. Энэхүү боломжийн хүрээнд бид бүхэн 2022 онд “Элемент” ХХК-тай хамтын гэрээ байгуулан химийн бодисын сав баглаа, боодлыг зориулалтын бүсэд устгуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

БАТЛАВ: "ЭЛЕМЕНТ" ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
/Б.ЭНХБАДРАЛ/

БАТЛАВ: "ЭКО НООС" ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
/М.БЯМБАДОРЖ/

**ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ ГЭРЭЭ**

№ ХБ-22/

2022 оны 11-р сарын 17-ний өдөр

Улаанбаатар хот

**НЭГ, НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Нэг талаас "Элемент" ХХК (дараахд гүйцэтгэгч гэх) төлөөлж, Химич албан тушаалтай А.Уранчимэг нөгөө талаас (дараахд захиалагч гэх) "Эко ноос" ХХК-ийг төлөөлж Менежер албан тушаалтай Б.Эрхбаяр бид харилцан гохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль болон бусад холбогдох хууль, Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар" А/505 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны "Аргачлал, норматив батлах тухай" А/605 дугаар тушаал болон бусад холбогдох дүрэм, журам, зөргийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь зориулалтын шатаах зуухны туршилтын шатаалтанд химийн бодисын хог хаягдлыг гэрээнд заасан хугацаанд ачиж тээвэрлэх, устгах, Захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

**ХОЁР, ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ**

- Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- Химийн бодисын хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дэх заалтын дагуу аюултай хог хаягдал савлагаа хадгалах сав нэг бүр нь "Аюултай хог хаягдал" гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх.
- Үүссэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах.

**ХАВСРАЛТ 1**

Энэхүү гэрээгээр зөвхөн доорх хог хаягдлыг хүлээн авч, тээвэрлэн устгана.

д/д	Хаягдлын нэр төрөл	Хаягдлын нийт хэмжээ, нэгж	Устгаа хний нэгж үнэ /төгрөг/	Устгаа хний үнэ /төгрөг/
1	Сала	12.6 кг	5,200.0	65,520.0
2	Борил давс	3.75 кг	5,200.0	19,500.0
3	Химийн бодис агуулж байсан болон үлдэгдэлтэй төмөр торх	12 ш	7,400.0	88,800.0

Бидантай хамтран ажилласанд баярлалав.  
Элемент ХХК

## ОЛОН НИЙТЭД ТАЙЛАГНАХ

2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт долоон бүлэг ажлуудыг төлөвлөн ажилласан. Эдгээр ажлуудыг зохион байгуулах, биелүүлэхэд нийт 1,349,000 төгрөг төсөвлөн ажилласан бөгөөд 2022 оны эцэст гүйцэтгэсэн ажилд нийт 24,197,148 төгрөг зарцуулан ажилласан байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг, тухайн орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлэн тайлагнана. Мөн Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газарт хүргүүлэн батлуулах юм.

2022 онд хийгдсэн ажлуудыг зарцуулсан зардлын хамт доорх хүснэгтэд нэгтгэв.

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Хийгдсэн ажлууд	Зардлын дүн /төг/
1	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Ноосноос гарах тоосжилтыг багасган, ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг бууруулах, үйлдвэрлэлийн дамжлагыг боловсронгуй болгож шинэ төхөөрөмжөөр сольсон ажилд	10,230,000
2		ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO14001:2015 Байгаль орчны менежментийн тогтолцооны хэрэгжилтийг ханган ажиллаж Магадлан аудит хийгдсэн	2,282,000
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Ноосны хаягдал, даахь, хөц зэргийг “ Монпеллетс ” ХХК-тай хамтарч ХАА-н бордоо болгох ажилд	2,500,000
4		Хаягдал өтгө бууцыг бордоо болгох ажилд	-
5	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Хаягдал усыг саарал ус болгон ашиглах ажилд	-
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	тоног төхөөрөмж болон цахилгааны трансформаторын аянга газардуулагчийн бүрэн бүтэн байдлыг шалган, трансформаторт ажиллагааны хяналтыг хийлгэсэн.	-
7	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Үйлдвэрийн хэмжээнд гадаа талбай зүлэгжүүлэлт болон ойр орчмын зэрлэгийг хадаж цэвэрлэх ажилд	250,000

8	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Уурын шугамыг шинэчилж хөрсөнд уур нэвчихээс сэргийлсэн шугам, засвар үйлчилгээний ажилд	8,695,148
9	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулах	240,000
<b>НИЙТ</b>			<b>24,197,148</b>

## ДУГНЭЛТ

2022 онд манай үйлдвэрлэлийн хувьд Ковид-19 цар тахалтай холбогдон хил гаальийн нөхцөл байдлаас үүдэн зогсонги байснаас шалтгаалан тухайнд онд батлуулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан ажлууд нь 70%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн. Үйлдвэрийн хэмжээнд гадаа талбай зүлэгжүүлэлт болон ойр орчмын зэрлэгийг хадаж цэвэрлэсэн, уурын шугамыг шинэчилж хөрсөнд уур нэвчихээс сэргийлсэн уурын шугамын засвар, мөн байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн процессийг нэмэгдүүлэх зорилгоор хонины ноосны бууц, өтөг зэргийг байгалийн бордоо болгон ашиглах, үйлдвэрлэлийн ялгалтаас гарч буй дайх ноос, хөдөс зэргийг бордоо болгон бордооны үйлдвэрт нийлүүлэх ажлыг зохион байгуулсан. Мөн томоохон ажлын нэг нь хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдлаас үүдэлтэй орчны бохирдол, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулахад өмнөх жилүүдэд орон нутагт устгалын цэг байдаггүйгээс үүдэн агуулахад хадгалдаг байсан бол энэ оноос Химийн бодисын сав баглаа, боодлыг устгах, дахин боловсруулах үйлдвэрүүд байгуулагдсанаар энэхүү нөлөөлийг 100% буруулах бүрэн боломж бий болсон. Энэхүү боломжийн хүрээнд бид бүхэн 2022 онд “Элемент” ХХК-тай хамтын гэрээ байгуулан химийн бодисын сав баглаа, боодлыг зориулалтын бүсэд устгуулах арга хэмжээг авч ажилласан явдал байлаа.

2022 онд хийгдээгүй ажлуудыг 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг ханган ажиллана.